

CRYPTO WEEK

powered by  ardcoin



Хөх Тэнгэр Төсөл

BS9

Токен Эзэмшигчдийн Хурал


КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Ард Пропертиз ХХК нь 2017 онд үүсгэн байгуулагдсан, Хөрөнгө Оруулагч Үндэстнийг цогцлоох эрхэм зорилготой Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай, үл хөдлөх хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа, засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын тусгай зөвшөөрөлтэй компани юм.

Ард Пропертиз нь байгуулагдсан цагаасаа эхлэн үл хөдлөх хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын хөрөнгийн менежментийг хариуцан ажиллаж байна.

КОМПАНИЙН ТУРШЛАГА

Тухайлбал Шангри-Ла салбар, Сэнтрал Тауэр салбар, Номын Хишиг оффис, Тэнгэр ТВ, Монгол Шуудан, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ болон орон нутгийн салбаруудыг дурдаж болно.



Сэнтрал Тауэр оффис



Монгол Шуудан



Тэнгэр ТВ



ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөх Тэнгэр төслийн гол зорилго нь технологийн дэвшлийг уламжлалт үл хөдлөх хөрөнгийн бизнестэй холбон хотын төвийн "А" зэрэглэлийн бүсэд орших үл хөдлөх хөрөнгийг дэлхийн хаанаас ч хэсэгчлэн эзэмшиж, тогтмол түрээсийн орлого хүртэх боломжийг хөрөнгө оруулагчдад олгох юм.

Уг төслийг 2022 оны 12 сараас эхлүүлсэн бөгөөд 2023 оны 7 сарын 1 –нд оффисийн засвар үйлчилгээний ажил нь бүрэн дуусаж түрээслэгч талдаа хүлээлгэн өгсөн. Тухайн сараас эхлэн хөрөнгө оруулагч нартаа эзэмшиж буй токены хувь хэмжээнд нь ноогдуулан түрээсийн орлогыг хуваарилж эхэлсэн.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн хүрээнд Блю Скай тауэрын 9 давхар буюу 1,455 м.кв талбайг Ард Пропертиз ХХК нь худалдан авч бүхлээр нь оффисийн зориулалттай орчин үеийн заслыг хийж гүйцэтгэсэн бөгөөд түрээслэгч талдаа нийт талбайн хэмжээгээр нь 5 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн болно.




Блю Скай Тауэр, 9 давхар

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Токены анхны нэрлэсэн үнэ нь 1,000 төгрөг байхаар тооцож 1,455 м.кв талбайг эзэмших эрх нийт 14,550,000 (Арван дөрвөн сая таван зуун тавин мянган) ширхэг токенод хуваагдсан байхаар бид технологи эдийн засгийн үндэслэлээ (ТЭЗҮ буюу англиар “Whitepaper”) боловсруулсан. Улмаар BS9 токеныг блокчэйн систем дээр үүсгэж, Айдакс бирж дээр бүртгүүлэн ажиллалаа.



Блю Скай Тауэр, 9 давхар



BS9 ТОКЕНЫ ТАРХАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Доорх хүснэгтээс BS9 токены Айдакс бирж дээрх тархалтын мэдээг харж болохоор байна.

2024.03.31 –ний өдрийн байдлаар

Интервал	BS9	Харилцагч
0-100	1,358	78
100-500	4,479.79	20
500-1,000	5,775.03	7
1,000-10,000	78,226.06	20
10,000-100,000	144,948.77	8
100,000-500,000	2,092,496.15	8
500,000+	12,222,461.20	7
Нийт	14,550,000	148

ТҮРЭЭСИЙН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ

Доорх хүснэгтэд түрээсийн орлогын мэдээлэл болон хасагдах татварын зардлыг дэлгэрэнгүй харуулсан болно.

Тайлбар	2023.07.01-2024.06.30	2025.07.01-2026.06.30
Түрээсийн орлого	1,311,651,540	1,573,981,848
НӨАТ 10%	119,241,049	143,089,258
ҮХХ 2%	261,453,249	261,453,249
Түрээс зуучлал 6.6%	86,569,001	103,882,801
Нийт зардал	467,263,299	508,425,309
Үлдэгдэл	844,388,240	1,065,556,538
Нийт токены тоо ширхэг	14,550,000	14,550,000
Нэгж токенод ноогдох төгрөг	58	73
Түрээсийн орлогын хуваарилалтын хувь	6%	7.32%

BS9 ТОКЕНЫ АРИЛЖАА

Бидний хамтдаа эхлүүлсэн төслийн ажил амжилттай хэрэгжиж нэг ширхэг токены ханш 2024 оны 03 сарын 31-ны өдрийн байдлаар 1,097 төгрөгтэй тэнцээд байна. Мөн BS9 токеныг эзэмших боломж нь Айдакс-д бүртгэлтэй бүх хэрэглэгчид нээлттэй бөгөөд 3 төрлийн хослолоор худалдан авах боломжтой байгаа.

Доорх хүснэгтээр BS9 токены арилжаа эхэлсэн өдрөөс хойшхи хослолуудын арилжааны ханшийн мэдээллийг харуулсан байна.

2023.04.21-2024.03.31 байдлаар

Хослол	Нийт арилжааны дүн	Тоо ширхэг	Жигнэсэн дундаж ханш	Арилжааны тоо ширхэг
BS9/ARDX	14,766,774.71	402,559	36.68	400
BS9/MONT	952,870,991.86	913,196.55	1,043.45	797
BS9/USDT	39,650.89	134,371.70	0.30	201

Ард Санхүүгийн Нэгдлийн санаачлан эхлүүлсэн уг ажлыг анхнаас нь дэмжин, хөрөнгө оруулалт хийж бидэнд итгэл хүлээлгэсэн нийт хөрөнгө оруулагч нартаа талархал илэрхийлье. Бид хөрөнгө оруулагчдадаа оруулсан хөрөнгө оруулалт нь хамгийн өндөр ашиг, өгөөжтэй байхын төлөө ажиллах болно. Цаашид бид уг төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ мөн Айдакс биржийн арилжааны мэдээг сар болгон илгээж байх болно.



Та бүхэн Хөх Тэнгэр төслийн бизнес төлөвлөгөө болон санхүүгийн тайланг доорх вэбсайт хаягаар орж дэлгэрэнгүй танилцаарай.

Вeб: <https://blue-sky.mn/>

Бидэнтэй шууд холбогдох хаяг:

Утас: +976 77003322

И- мэйл: contact@ardproperties.mn